



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/648

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 45 дугаар зүйлийн 45.1, 45.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаар шийдвэр, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаар шийдвэрээр гуравдагч этгээд Г.Цэдэндамба (РЮ53101707)-ын Хөвсгөл аймгийн Засаг даргад холбогдуулан гаргасан бие даасан шаардлагыг бүхэлд нь хангаж, Б.Лхамсүрэн агсны газар эзэмших эрхийн анхдагч гэрээнд заасан газар эзэмших хугацаа дуусвал өвлөгч Г.Цэдэндамбад газрыг үргэлжлүүлэн эзэмшүүлэх шийдвэр гаргахыг Хөвсгөл аймгийн Засаг даргад даалгасан бөгөөд уг шийдвэртэй холбогдуулан гарсан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/26 тоот шийдвэрт иргэн Г.Цэдэндамбад 3050м<sup>2</sup> газрыг Мөрөн сумын 8 дугаар баг 9-49 тоотод байршилтай 6712017170 нэгж талбартай газрыг “Худалдаа эд хэрэглэгчдийн хоршоодын холбоо” (РД:1018337)-ын газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн газартай давхцуулан шийдвэр гаргасныг залруулан 6712008669 нэгж талбарын дугаартай үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн аймгийн Засаг даргын 2012 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/238 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 10 дахь хэсгийн 5 дахь мөрөнд 3213м<sup>2</sup> гэснийг багасган кадастрын хэмжилтээр 1463м<sup>2</sup> гэж өөрчилж газрын зориулалтыг газрын кадастрын системийн газрын нэгдмэл сангийн ангилалд нийцүүлэн худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай болгон үлдсэн 21 жилийн хугацаатайгаар газар эзэмшигч хуулийн этгээд “Худалдаа эд хэрэглэгчдийн хоршоодын холбоо” (РД:1018337)-д эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/238 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтын 10 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээд “Худалдаа эд хэрэглэгчдийн хоршоодын холбоо” (РД:1018337)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

6712012017

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР